



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/286

Чингис хот

Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуулийн хугацаанд төлөөгүй, хайгуулын үйл ажиллагааны тайлан гүйцэтгэлийг зөвшөөрсөн хугацаанд ирүүлээгүй “Аюурфарм” ХХК-ийн Цэнхэрмандал сумын нутаг дахь Хавцалын адаг нэртэй 115.81 га талбай бүхий XV-23000008 дугаартай, “Тулга-Өгөөж” ХХК-ийн Хэрлэн сумын нутаг дахь Саригийн хөндий нэртэй 50.04 га талбай бүхий XV-23000022 дугаартай, Саригийн хөндий нэртэй 35.5 га талбай бүхий XV-23000023, Дулаан нэртэй 87.1 га талбай бүхий XV-23000025 дугаартай Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг тус тус цуцалсугай.

2. Тусгай зөвшөөрөл цуцалсан тухай шийдвэрийг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Цэнхэрмандал, Хэрлэн сумдын Засаг дарга нарт тус тус мэдэгдэж, Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Хайгуулын ажил хийгдсэн талбайд тухайн тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан аж ахуйн нэгж компаниар нөхөн сэргээлт хийлгүүлж, байгаль орчны хохирлыг барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг Цэнхэрмандал сумын Засаг дарга /С.Золжаргал/, Хэрлэн сумын Засаг дарга /Ц.Идэрбат/ нарт даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны А/198, 2016 оны А/177 дугаартай Тусгай зөвшөөрөл олгох тухай захирамжуудын “Аюурфарм” ХХК, “Тулга-Өгөөж” ХХК-д хамаарах хэсгүүдийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА